# МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Н.МӨНХЗУЛЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин: Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин: Хүрэх түвшин | Гүйцэтгэлийн түвшин: Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1: Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах** | | | | | | | |
| 1 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /1.1.26.Гадаад худалдааны цахим нэг цонхны системийг бий болгох/ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | "Цахим нэг цонхны систем"-тэй гаалийн байгууллагын үйл ажиллагаа холбох туршилтын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангасан байна. | 1. “Цахим нэг цонхны систем"-тэй гаалийн байгууллагын үйл ажиллагааг холбох туршилтын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд:<br>• Засгийн газрын 2023 оны “ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ, УУЛ УУРХАЙН БУС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” 178 дугаар тогтоолын нэгдүгээр хэсэгт "Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн системийг бий болгох, гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагааг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан эхлүүлэх арга хэмжээг Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран хэрэгжүүлэхийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Хөрөнгө оруулалт, худалдааны газар, Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал)-т даатгасан.<br>• Уг ажлын хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/184 тушаалаар "Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн системийг бий болгох, гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагааг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан эхлүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Тухайн ажлын хэсэгт Гаалийн ерөнхий газраас Хяналт, бүрдүүлэлтийн газрын ГУАБ Ц.Цэвээндарь, ГУБ Л.Амартүвшин, Мэдээллийн технологийн газрын дарга Б.Ганзориг, ГУАБ Н.Мөнхзул, ГУБ З.Алтанхуяг, ХЦГ-н ГУАБ Т.Төмөрбаатар, УБГГ-н ГУБ Ц.Гэндэнцэвээн нар орж ажиллаж байна. | 01.01-11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | • 2024 оны 3 дугаар сарын 21ны өдөр "Гадаад худалдааны цахим нэг цонх"-ны бүх оролцогч талуудыг оролцуулсан уулзалтыг ХҮСБНТ-ийн нэгжээс зохион байгуулсан. Уг уулзалтад 19н байгууллагын 40н оролцогч оролцсоноос Гаалийн ерөнхий газрын дэд дарга Г.Энхтайван, МТГ-н ГУАБ Н.Мөнхзул нар оролцсон.<br>• Азийн хөгжлийн банктай хамтран Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн цахим нэг цонх хариуцсан гадаад зөвлөх Training on single windows data harmonization, Training on single window business process reengineering сургалтуудыг 2024.03.21-нд 14:00-18:00, 2024.03.22-нд 09:00-17:00-ын хооронд ГЕГ-ын 9 давхарт зохион байгуулсан. Тус сургалтад ЗББНДБ-ын нийт 18 албан хаагч оролцсон.<br>• "Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн системийг бий болгох, гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагааг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан эхлүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийн хуралдаан 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулагдсан. Тус хуралдаанд МТГ-ын ГУАБ Н.Мөнхзул оролцсон<br>• Ажлын хэсгээс Төрийн болон төрийн бус байгууллагуудаас гадаад худалдаатай холбоотой олгож буй зөвшөөрөл, лиценз, гэрчилгээний талаарх судалгааг хийсэн. Тус судалгаанд гаалийн байгууллагаас олгож буй экспорт, импортын гэрчилгээ, мэдэгдлийн судалгааг ХБГ-с гаргаж өгсөн. Мөн АХБ-ны гадаад зөвлөхтэй Гаалийн цахим системүүдийн талаарх мэдээлэл өгч, хамтран ажилласан.<br>• Олон улсын цахим нэг цонхны зөвлөх Эва RIBS, BEST 2 төслийг нэгтгэсэн Англи хэл дээрх (АХБ-ны формат бүхий) ажлын даалгаврыг ЦНЦ-ны ажлын хэсэгт ирүүлсэн. Төслийн нэгжээс Монгол хэлээр хөрвүүлсэн ба ажлын хэсгийн гишүүд уг ажлын даалгавартай танилцаж, засвар өөрчлөлтийн саналыг өгсөн.<br>• 2024 оны 10 дугаар сард АХБ-ны гадаад зөвлөх ЦНЦ-ны ажлын даалгаварт ажлын хэсгээс болон ЦХХХЯ-с өгсөн саналыг оруулж, ЭЗХЯамтай уулзалт хийн ажлын даалгаврын сүүлийн хувилбарыг өгсөн. ЭЗХЯамнаас ажлын даалгаврыг баталсан. Мөн АХБ-ны гадаад зөвлөх тендерийн баримт бичгийг боловсруулж байгаа ба 2024 оны 10 дугаар сард Цахим нэг цонхны зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдсан. Гаалийн байгууллагаас үнэлгээний хороонд оролцоогүй. | | |
| **Зорилт 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Мэдээллийн нэгдсэн санд дүн шинжилгээ хийж, өгөгдлийг боловсруулсан байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1.Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн (RIBS) хүрээнд хийгдсэн гаалийн мэдээллийн системийн шинэчлэлийг бүрэн нэвтрүүлэх, баталгаат засварын хугацаанд сайжруулалт хийхэд гүйцэтгэгч компанитай хамтран ажиллана. Гаалийн мэдээллийн системүүдийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж, нэвтрүүлэлтийг жигдрүүлсэн байна.<br>2.Их өгөгдлийн өгөгдлийн санг зохион байгуулж, Tableau програмыг ашиглан мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх, дашбоард хөгжүүлсэн байна.<br>3.Хиймэл оюу ухаанд суурилсан БТКУС кодыг санал болгох системийг шинээр нэвтрүүлсэн байна. | 1. Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн (RIBS) хүрээнд хийгдсэн гаалийн мэдээллийн системийн шинэчлэлийг бүрэн нэвтрүүлэх, баталгаат засварын хугацаанд сайжруулалт хийхэд гүйцэтгэгч компанитай хамтран ажиллах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.<br>1) Бүрдүүлэлтийн дараах шалгалтын системийн бизнес процессд дараах нэмэлт сайжруулалтыг хийсэн.<br>• Бүрдүүлэлтийн дараах шалгалтад томилогдон ажиллах ГУАБ, ГУБ нарын шалгалтын хуваарийг автоматаар хийх, маягтуудыг PDF хэлбэрээр харах боломжтой болсон.<br>• БДШГ-аас ирүүлсэн журмын дагуу програмд засвар өөрчлөлтийг хийсэн.<br>• ААН-ийг шалгах хүсэлтийг ЭУХ-ээс БДШГ-луу хүсэлт илгээх боломжийг бүрдүүлсэн.<br>• Тайлан боловсруулах (дашбоард) хэсэгт нэмэлт хөгжүүлтийг хийсэн.<br>• Нэхэмжлэлийг ААН-ээр ГУБ үүсгэж, гааль.мн системээс ААН харах боломжтой болсон.<br>• Симс системд ГУБ үр дүнгийн мэдээллийг бүртгээд КАИС системрүү илгээх<br>• Симс системд ААН-ийн зөрчлийн мэдээллийг татах<br>2) Тээврийн хэрэгслийн бүртгэлд нэмэлт өөрчлөлт хийх ажлын хүрээнд дараах ажлыг нэмэлт хөгжүүлэлтийг хийсэн.<br>• Хил дээрх машины хүсэлт дээр барааны мэдээлэл бүртгэх<br>• Ханги дахь гаалийн газар, Дорнод аймаг дахь гаалийн газар, Бичигт гаалийн газруудад тээврийн бүртгэл автоматаар үүсгэх тохиргоо өөрчлөлт<br>• ЗҮГГ-ын нүүрсний бүрдүүлэлтэд тээврийн бүртгэл автоматаар үүсгэх тохиргоо өөрчлөлт<br>3) Манифестын нэмэлт өөрчлөлт<br>• Дотоодын дамжин өнгөрөх манифестыг бусад байгууллагаас мэдээлэл холбох API функцийн хөгжүүлэлт<br>• Дотоодын дамжин өнгөрөх манифестыг бусад байгууллагаас мэдээлэл татаж мэдээллийг нөхөн бөглөх процессыг хялбаршуулсан.<br>4) Экспортын мэдүүлгийн нэмэлт хөгжүүлэлт<br>• Төмөр замын захиалгын хуудас мэдүүлгийн системд холбох хөгжүүлэлт | 01.01-11.30 | 100 |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>

- Улсын төсөвт үйлдвэрийн газрын тээврийн гэрээний сервис холбох хөгжүүлэлт хийгдсэн.
- Мэдүүлэг дээрх дотоодын дамжин өнгөрөх манифест холбох хөгжүүлэлт

5) Хяналтын бүсийн үлдэгдлийн модуль дээр Улсын төсөвт үйлдвэрийн газрын тээврийн гэрээний сервис холбох хөгжүүлэлт

2. Мэдээлэл боловсруулах Өгөгдөлд дүн шинжилгээ хийх, дашбоардын ачааллах хурдыг сайжруулах зорилгоор Их өгөгдөлд суурилсан шинэ архитектураар Data warehouse буюу өгөгдлийн агуулах үүсгэсэн.

- Гаалийн мэдээллийн санд дүн шинжилгээ хийх өгөгдлийн сангийн орчинг бий болгох ажлын хүрээнд Novelsoft компанитай хамтран Tableau програмыг ашиглан хэрэгцээтэй дашбоардуудыг боловсруулж, сервер дээр байршуулсан. Үүнд:
  - Гаалийн орлогын гүйцэтгэлийн мэдээ
  - Бараа эргэлтийн тайлан
  - Хилийн хөдөлгөөний мэдээ
  - Экспортын статистик мэдээлэл
  - Импортын статистик мэдээлэл

  Тус тайлан мэдээнд дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлсэн.

3. Гадаад худалдаанд оролцогчид гаалийн мэдүүлгийг нөхөн бичихэд гарч буй хүндрэлийн нэг нь тухайн бараанд таарах зөв БТКУС-г олох асуудал байдаг учраас “Хиймэл оюу ухаанд суурилсан БТКУС код санал болгох систем”-г хөгжүүлж эхэлсэн. Импорт, экспортын барааны нэр, марк модел, онцлог шинж гэсэн талбаруудыг авч өгөгдлийн бэлтгэн, цэвэрлэж ДГБ-н БАКУДА төслөөс санал болгосон Doc2Vec моделийг ашиглан машин сургалтаар моделийг сургасан. Doc2Vec бол баримт (document) эсвэл текстийн цогц мэдээллийг векторын хэлбэрт хувиргаж, машин сургалтанд ашиглахад тохиромжтой хэлбэрт оруулах зориулалттай байгалийн хэл боловсруулалтын (NLP) аргачлал юм. Машин сургалтаар мэдүүлгийн өгөгдлийн сангаас сүүлийн 3н жилийн датагаар машин сургалтын хийж accuracy буюу моделийн магадлал 80-с дээш хувьтай гарч системийн эхний хувилбар бэлэн болсон. Үүнийг Барааны ангилал, үнэлгээний хэлтсээс туршилт хийж, ДГБ-т албан хүсэлтээр мэдэгдэж, 2025 онд нэвтрүүлэхээр төлөвлөж байна.

</td><td></td><td></td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгох, аюулгүй байдлыг хангах, тоног төхөөржмийн судалгаа хийсэн байдал. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1.Систем, сүлжээ, серверүүдэд мониторинг хийх, тасралтгүй хэвийн найдвартай ажиллагаа, нууцлал, хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг хангасан байна.<br>2.Шаардлагатай тохиолдолд тоног, төхөөрөмжийн холбогдох судалгааг хийх, төлөвлөх, хуваарилах, ашиглалтад хяналт тавих, засвар үйлчилгээ хийнэ. | 1. Систем, сүлжээ, серверүүдэд мониторинг хийх, тасралтгүй хэвийн найдвартай ажиллагаа, нууцлал, хадгалалт, хамгаалалт аюулгүй байдал<br>• Гаалийн байгууллагын төрийн цахим хуудсыг шинэчилж сайжруулах ажлын хүрээнд шинээр нэвтрүүлж байгаа цахим хуудсыг /customs.gov.mn/ үндэсний дата төвийн түрээсийн хийсвэр сервер дээр байршуулах явцад маш ихээр удах, гацах, зарим тохиолдолд шинээр байршуулсан цахим хуудас бүрэн ачааллаж гарч ирэхгүй байх, ердөө 1 цахим хуудас байршуулахад бүтэн 3~5 ажлын өдөр зарцуулж байгаа нь бидний шаардлагад нийцэхгүй байгаа тул үндэсний дата төвд хүсэлт тавьж гаалийн байгууллагын өөрийн сервер дээр нүүлгэн шинээр ажиллах орчин бэлдэн байршуулж ажиллуулсан бөгөөд гаалийн газар 19 хороо тус бүрд цахим хуудсыг байршуулахад хамгийн ихдээ 20~40 минутанд хуулж байршуулдаг болсон ба тус системийг өөрийн дата төвд байршуулах нь нөөцлөлт архивыг өдөр тутам хийж болдог болсон.<br>• Бүрдүүлэлтийн цахим төвийн засварын ажил дууссан тул хэрэглэгчийн сүлжээг шалгаж хэвийн ажиллагаанд оруулсан. Тус газрын сүлжээг ГЕГ-ын сүлжээнд шинээр зохион байгуулж, 60 хэрэглэгчийг сүлжээнд холбож, хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажилласан. Мөн Бүдүүлэлтийн цахим төв байрлаж байгаа байранд бүрэн засварын ажлын хийж, сүлжээний холболтыг хүлээн авч сүлжээний дэд бүтэц дээр суурилуулах тоног төхөөрөмжийн тооцооллыг гаргаж шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн худалдан авалтын хийж төхөөрөмжүүдийг суурилуулаж сүлжээний холболт тохиргоог хийж компьютер техник хэрэгсэлүүдийг угсарч нэг бүрчлэн сүлжээнд холбон бүрдүүлэлтийн цахим төвийг хэвийн ажиллагаанд оруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>2. Дата төвийн өргөтгөл шинэчлэл, хэвийн найдвартай ажиллагааг хангах ажлын хүрээнд:<br>• Мэдээллийн аюулгүй байдлын газраас Гаалийн байгууллагын дата төвийн систем сүлжээний орчинд Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хийж, зөвлөмжийг ирүүлсэн.<br>- Мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдлын бодлого, дүрэм, журам, төлөвлөлт, орчны аюулгүй байдал;<br>- Системийн аюулгүй байдал;<br>- Сүлжээний аюулгүй байдал;<br>- Программ хангамжийн аюулгүй байдал; | 01.01-11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Серверийн өрөөний аюулгүй байдал;<br>- Өгөгдлийн сангийн нөөцлөлт аюулгүй байдал<br>Гаалийн байгууллагад ирүүлсэн зөвлөмжийн дагуу шаардлагатай тоног төхөөрөмж, системүүд дээр өөрчлөлт, тохиргоог хийж, тус газарлуу хариуг хүргүүлсэн. Тус зөвлөмжийн дагуу гаалийн байгууллагын дата төвийн үндсэн сүлжээний тоног төхөөрөмж болон бусад шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг шинэчлэн сайжруулах зөвлөмж өгсөний дагуу гаалийн байгууллагын зүгээс шаардлагатай төхөөрөмжүүдийн худалдан авч, суурилуулж, ажиллагаанд оруулж, тохиргоог хийн ажиллаж байна.<br>• Гаалийн байгууллагын сүлжээний дэд бүтцийг сайжруулах зорилгоор дата төвд ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн шинэчлэх ажлыг 2024-11-25наас 2024-11-26ны өдрийг дуустал зохион байгуулсан. Гаалийн систем сүлжээг 24 цаг зогсоож, хуучин ашиглаж байсан 8 тоног төхөөрөмжийг салгаж, сүлжээний 12, сервер 2, нийт 32 тоног төхөөрөмжийг шинээр суурилуулсан. Гаалийн 21 газар хороод болон 160 хяналтын бүс, баталгаат агуулах, чөлөөт бүсүүдийн сүлжээний тохиргоог шинэчлэн хийж хэвийн ажиллагаанд оруулсан. Уг ажлыг МТГ-ын 8 албан хаагч 40 цаг турш ажиллан, үр дүнтэйгээр шинэчлэсэн. | | |
| 4 | Программ хангамжуудыг шинээр боловсруулах, хөгжүүлсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1.Захиргаа дотоод ажлын системийн нэмэлт хөгжүүлэлт болон засвар өөрчлөлтүүдийг ЗББНДБ-ын дотоод зурвасын дагуу хийж гүйцэтгэнэ;<br>2.Гаалийн автоматжуулсан мэдээллийн системийн шинэчлэх, сайжруулах хөгжүүлэлтийг ЗББНДБ-ын дотоод зурвасын дагуу хийж гүйцэтгэнэ.<br>3.Гаалийн баталгаат бүсийн үйл | 1. Захиргаа дотоод ажлын системд ЗББНДБ-ын програмын даалгаврын дагуу 11 удаагийн нэмэлт хөгжүүлэлт болон засвар өөрчлөлтүүдийг хийж гүйцэтгэсэн.<br>2. Гаалийн автоматжуулсан мэдээллийн системийг шинэчлэх, сайжруулах хөгжүүлэлтийг хийх ажлын хүрээнд 67 удаагийн засвар өөрчлөлт, нэмэлт хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн.<br>3. Гаалийн баталгаат бүсийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, гаалийн хяналтын бүс тогтоолгох, тээвэрлэгч байгууллагад олгодог гаалийн итгэмжлэл авах, түр агуулах ажиллуулах хүсэлтийг хүлээн авч, хянаж, шийдвэрлэх license.mn-д хөгжүүлэлт хийлгэх саналыг ГТСМТТ УҮГ-т хүргүүлнэ.<br>4. Татваргүй барааны дэлгүүрийн программыг бүрэн нэвтрүүлж, горимын хэрэгжилтийг сайжруулна.<br>5. Алтанбулаг чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа дэлгүүрүүдэд тавих хяналтыг сайжруулах программыг нэвтрүүлсэн. | 01.01-11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, гаалийн хяналтын бүс тогтоолгох, тээвэрлэгч байгууллагад олгодог гаалийн итгэмжлэл авах, түр агуулах ажиллуулах хүсэлтийг хүлээн авч, хянаж, шийдвэрлэх license.mn-д хөгжүүлэлт хийлгэх саналыг ГТСМТТ УҮГ-т хүргүүлнэ.<br>4.Татваргүй барааны дэлгүүрийн программыг бүрэн нэвтрүүлж, горимын хэрэгжилтийг сайжруулна.<br>5.Алтанбулаг чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа дэлгүүрүүдэд тавих хяналтыг сайжруулах программыг нэвтрүүлнэ. | | | |
| 5 | Албан хаагчдын чадавхыг бэхжүүлсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Гаалийн ерөнхий газрын Мэдээллийн технологийн асуудал хариуцсан албан хаагчдыг мэдээлийн технологийн чиглэлээр чадавхжуулах боломжийг хангаж ажилласан байна. | 1. Мэдээллийн технологийн асуудал хариуцсан албан хаагчдыг мэдээллийн технологийн чиглэлээр чадавхжуулах боломжийг хангах ажлын хүрээнд:<br>• ГУАБ Н.Мөнхзул нь Дэлхийн гаалийн байгууллагын "BACUDA дата аналитикийн хөтөлбөр"-т хамрагдан, БНСУ-ийн Сувон хотод байрлах Sungkyunkwan их сургуульд Их өгөгдөл, Машин сургалт, Дата аналитикийн чиглэлээр 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хооронд 5 сарын хугацаатай суралцсан.<br>• 2024.08.15ны өдөр Novelsoft XXK-иас Mulesoft програмын сургалтад хамрагдсан. | 01.01-11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | • Өгөгдлийг өөр хоорондоо нь холбох, шинжлэн нэгтгэх, интерактив дашбоард боловсруулах зэрэг өгөгдөл дүрслэлийн ур чадварыг өндөр түвшинд эзэмших Tableau Desktop I&II түвшин буюу анхан шатны сургалтад 2024.10.23-2024.10.24-ны хооронд хамрагдсан.<br>2. Зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагын албан хаагчдад мэдээ, мэдээлэл олгох сургалтыг зохион байгуулах ажлын хүрээнд:<br>• Азийн хөгжлийн банктай хамтран Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн цахим нэг цонх хариуцсан гадаад зөвлөх цахим нэг цонхтой холбоотой Training on single windows data harmonization, Training on single window business process reengineering сургалтуудыг 2024.03.21-нд 14:00-18:00, 2024.03.22-нд 09:00-17:00-ын хооронд ГЕГ-ын 9 давхарт зохион байгуулсан. Тус сургалтад ЗББНДБ-ын нийт 18 албан хаагч оролцсон.<br>• Харьяа гаалийн газар хороодын мэдээллийн технологи хариуцсан албан хаагчдад Гаалийн бүрдүүлэлтийн явцад Мэдээллийн технологитой холбоотой гарсан асуудлыг шийдвэрлэх, системүүдийн шинэчлэлтэй холбоотой мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан.<br>Сургалтын сэдэв:<br>- КАИС системийн лабораторийн модуль<br>- Тээвэр<br>- Ухаалаг гарц<br>- Чингэлэг<br>- Сүлжээ, тоног төхөөрөмж<br>- Идок системд тоон гарын үсгээр баталгаажуулалт хийж, цахимаар албан бичиг солилцох<br>- Tableau програмыг ашиглан Гаалийн байгууллагын мэдээлэлд хэрхэн боловсруулалт, дүн шинжилгээ хийх дашбоард хөгжүүлсэн талаар<br>- Гаалийн системийн шинэчлэл, хиймэл оюун ухаан<br>• 2024.09.17-ны өдөр Бүрдүүлэлтийн цахим төвийн алба хаагч нарт КАИС, СЭПС системд хийгдсэн доорх өөрчлөлтүүдийн талаар сургалт орсон.<br>- Гаалийн импортын мэдүүлэгт эм, эмнэлгийн хэрэгслийн импортын зөвшөөрлийг ЭЭХХЗГ-с цахимаар татаж, мэдүүлэг зөвшөөрөгдөхөд мэдүүлгийн тоо хэмжээ болон бусад мэдээллийг цахимаар илгээж байгаа. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Архи, согтууруулах ундааны гаалийн бүрдүүлэлтэд ХХААХҮЯамнаас олгож буй импортын зөвшөөрлийг цахимаар татаж хянах.<br>- ОАТ-тай архи, согтууруулах ундаандТатварын Ерөнхий газраас олгож буй акцыг гаалийн мэдүүлэгт татах, ОАТ-н акцыг олгохдоо гаалийн мэдүүлгийг ашиглаж байна.<br>- Баркод, ХХААЯ-ны импортын зөвшөөрөл, ЭЭХХЗГ-н импортын зөвшөөрлийн тохиргоог БТКУС код бүрээр тохируулах боломжтой.<br>• БАҮХ-тэй хамтран СЭПС системд шинээр хийгдсэн доорх ажлуудын талаарх Гаалийн зуучлагч нарт сургалт явуулсан.<br>- Гаалийн импортын мэдүүлэгт эм, эмнэлгийн хэрэгслийн импортын зөвшөөрлийг ЭЭХХЗГ-с цахимаар хэрхэн татах<br>- Архи, согтууруулах ундааны гаалийн бүрдүүлэлтэд ХХААХҮЯамнаас олгож буй импортын зөвшөөрлийг цахимаар хэрхэн татах<br>- ТЕГ-с ОАТ-тай бараанд олгосон акцыг гаалийн мэдүүлэгт хэрхэн татах<br>• Өгөгдлийг өөр хооронд нь холбох, шинжлэн нэгтгэх, интерактив дашбоард боловсруулах зэрэг өгөгдөл дүрслэлийн ур чадварыг өндөр түвшинд эзэмших Tableau Desktop I&II түвшин буюу анхан шатны сургалтыг Novelsoft компанитай хамтран 2024.10.23-2024.10.24-ны хооронд зохион байгуулсан.<br>3. Гаалийн байгууллага болон бусад байгууллагаас зохион байгуулсан сургалт:<br>• Үндэсний статистикийн хорооноос ирсэн албан бичгийн дагуу “Төрийн нэгдсэн мэдээллийн сан байгуулах бэлэн байдал” сэдэвт уулзалтад 2024.03.05-ны өдөр оролцсон.<br>• Зүүн болон Зүүн хойд Азийн үр ашигтай төмөр замын дамжин өнгөрөх тээврийн хил дамнасан цахим мэдээллийн солилцоог дэмжих төслийн холбоо баригч нарын 2 дугаар уулзалт 2024.04.01-05-ны өдрүүдэд Узбекстан улсын Самарканд хотод, Ази Номхон Далайн Худалдааг Хөнгөвчлөх 11 Дэх Удаагийн Форумын үеэр зохион байгуулагдсан уулзалтад оролцсон. Хурлын тайланг ЗДАС-д байршуулсан.<br>• Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны А3 сургалтад 2024.05.14-05.16 хооронд хамрагдаж, 2024.05.17-ны өдөр шалгалт өгч тэнцсэн. | | |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>

- ДГБ-с зохион байгуулсан “Дэвшилтэт технологи”-н Ази номхон далайн бүс нутгийн сургалтад 2024.09.23-2024.09.27-ны хооронд хамрагдсан.
- “Гааль, Татварын Байгууллагын Цахим системээр үзүүлэх үйлчилгээнд үүсч байгаа хүндрэл, бэрхшээл, түүнийг шийдвэрлэх нь” Сэдэвт Хэлэлцүүлэгт газрын ГУАБ Н.Мөнхзул оролцож, “Гаалийн байгууллагын цахим системээр үзүүлж байгаа төрийн үйлчилгээнд үүсч буй хүндрэл бэрхшээл” сэдвээр илтгэл тавьсан. Хэлэлцүүлгийн үр дүнд цаашид 3 байгууллагын хамтран хийж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулсан.

</td><td></td><td></td></tr>
<tr><td>7</td><td>Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт</td><td>Үйл ажиллагаа</td><td>-</td><td>Сүүлийн хагас жилд:<br>1.Гадаад худалдааны статистик мэдээллийг хүлээн авсан хэрэглэгч (хандалт), цахим лавлагаа авсан хэрэглэгчийн тоо өмнөх оны мөн үеэс 5 хувиар өссөн байна.<br>2.Хэрэглэгчдийн мэдээлэл авах хүсэлтийг цахимаар авдаг, хүргүүлдэг болсон байна.<br>3.Гадаад худалдааны порталд “Автомат хариулагч”-аар мэдээлэл өгөх боломжийг бүрдүүлсэн байна.<br>4. Гаалийн байгууллагаас олгож буй Гаалийн түр агуулах ажиллуулах зөвшөөрөл, ТИР горимоор тээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрөл олгох, Оюуны</td><td>

1. Гаалийн цахим үйлчилгээний систем (гааль.мн)-ээр лавлагаа авсан хэрэглэгчийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

<table>
<tr><th></th><th>2023</th><th>2024</th><th>Өссөн хувь</th></tr>
<tr><td>Гаалийн байгууллагад татварын өртэй эсэх тодорхойлолт (ААН)</td><td>379</td><td>434</td><td>14.5%</td></tr>
<tr><td>Гаалийн зөрчлийн лавлагаа (Иргэн)</td><td>94</td><td>171</td><td>81.9%</td></tr>
<tr><td>Гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн барааны лавлагаа (ААН</td><td>7360</td><td>8223</td><td>11.7%</td></tr>
<tr><td>Гаалийн байгууллагад татварын өртэй эсэх тодорхойлолт (Иргэн)</td><td>293</td><td>379</td><td>29.3%</td></tr>
<tr><td>Гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн барааны лавлагаа (Иргэн)</td><td>1933</td><td>10674</td><td>452%</td></tr>
<tr><td>Гаалийн зөрчлийн лавлагаа (ААН)</td><td>298</td><td>377</td><td>26.5%</td></tr>
</table>

2. Хэрэглэгчдийн мэдээлэл авах хүсэлтийг цахимаар авах, хүргүүлэх ажлын хүрээнд:

<table>
<tr><th></th><th>2023</th><th>2024</th><th>Өссөн хувь</th></tr>
<tr><td>Авто тээвэр</td><td>1463826</td><td>2405856</td><td>64.3%</td></tr>
</table>

</td><td>01.01-11.30</td><td>100</td></tr>
</table>

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>өмчийн эрхэд хамаарах барааг гаалийн бүртгэлд бүртгэх, Экспортлогч, импортлогч аж ахуйн нэгжид гаалийн итгэмжлэл олгох зөвшөөрлийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлснээр аж ахуйн нэгжээс гаалийн байгууллагад гаргасан хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх, олгох явцыг ил тодорхой болгож, хяналтыг сайжруулна.</td>
<td>
<table>
<tr><td>Агаар</td><td>6684</td><td>9319</td><td>39.4%</td></tr>
<tr><td>Төмөр зам</td><td>20444</td><td>21181</td><td>3.6%</td></tr>
<tr><td>Импорт манифестын тоо</td><td>147797</td><td>181415</td><td>22.7%</td></tr>
<tr><td>Транзит манифестын тоо</td><td>190601</td><td>197078</td><td>3.3%</td></tr>
<tr><td>Дотоодын дамжин өнгөрүүлэх манифест</td><td>79080</td><td>151761</td><td>91.9%</td></tr>
<tr><td>Экспорт, Импортын барааны гаалийн мэдүүлэг</td><td>814080</td><td>952224</td><td>16.9%</td></tr>
<tr><td>Автомашины гаалийн мэдүүлэг</td><td>102103</td><td>161513</td><td>58.1%</td></tr>
</table>
<br>
3. Гадаад худалдааны портал “Автомат хариулагч”-аар мэдээлэл өгөх боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд<br>
- Гаалийн лавлах 1281 болон МТГ-н 353558 утсанд дуудлага маш их ирдэг. Энэ жилийн байдлаар МТГ-н утсанд нийт 2,592 дуудлага ирсэн байна. Утасны дуудлагын тоог багасгах, гадаад худалдаа эрхлэгчдийг мэдээллийг хангахын тулд Гаалийн холбогдолтой асуултад хариул өгөх Хиймэл Оюу ухаанд суурилсан Чатбот-г хөгжүүлж эхэлсэн. Энэ чатбот нь бэлтгэсэн текс, асуулт хариултаар OpenAI API-г ашигласан хэрэглэгчийн асуултад хариулт өгөх систем юм. ХБГ, ХЦГ, МТГ-т байнгын давтамжтай ирдэг асуултыг гаргаж, түүнд хариулт бэлтгэн модел сургалт хийсэн. Чатботын туршилтын хувилбар 2024-09 сард гарсанг турших үзээд, өмнө нь бэлтгэсэн асуултын хариултын чанарыг сайжруулан дахин модел сургалт хийж байна. Чатботын туршилт хийсэн үр дүн болон бэлтгэсэн асуулт хариултыг хавсралтаар оруулав.<br>
4. Гаалийн байгууллагаас олгож буй дараах зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлэх:
</td>
<td></td>
<td></td>
</tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | • Гаалийн түр агуулах ажиллуулах зөвшөөрөл<br>- Санхүүгийн мэдээллийн технологийн төв УТҮГ-с хөгжүүлэлтийг хариуцдаг. Гаалийн түр агуулах ажиллуулах зөвшөөрлийг цахимжуулах бол ХБГ-с бодлогын даалгаврын УТҮГ-т гарган хийгдэх боломжтой.<br>• ТИР горимоор тээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрөл олгох<br>- Зөвшөөрлийн цахим систем /www.license.mn/ -г Санхүүгийн мэдээллийн технологийн төв УТҮГ-с хөгжүүлэлтийг хариуцдаг. ТИР горимоор тээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрлийг цахимжуулах бол ХБГ-с бодлогын даалгаврын УТҮГ-т гарган хийгдэх боломжтой.<br>• Оюуны өмчийн эрхэд хамаарах бараага гаалийн бүртгэлд бүртгэх<br>Гаалийн цахим үйлчилгээний гааль.мн системийн бүртгэл хэсэгт ААН нь Оюуны өмчийн эрхэд хамаарах бараа бүртгүүлэх хүсэлтийг гаргах програмын хөгжүүлэлт хийсэн. Уг гаргасан хүсэлтийг СИМС системд хүлээн авах, хянан баталгаажуулалт хийх хөгжүүлэлт хийсэн.<br>ХБГ-н 467 тоот дотоод зурвасын дагуу оюун өмчийн эрхэд хамаарах бараа бүртгэх програмд өөрчлөлт оруулсан. Уг програмыг туршилт хийсний дараа нэвтрүүлэхээр төлөвлөж байна.<br>• Экспортлогч, импортлогч ААН-д гаалийн итгэмжлэл олгох зөвшөөрлийн програмд дараах засвар өөрчлөлтийг хийсэн.<br>- Cims.gaali.mn системийн ИААН-ийн програмд ажлын байрны шалгалтын үнэлгээ өгөх модуль, нэмэлт шаардлагатай засвар өөрчлөлтийг оруулсан.<br>- Шалгуур үзүүлэлтэд нэмэлтээр файл хавсаргах боломжтой болгох;<br>- ААН шалгуур үзүүлэлтийн файл оруулах хэсэгт 1 файл оруулдаг байсныг олон файл оруулах боломжтой болгосон;<br>- ИААН-г хянан шалгаж буй ГУБ нь шаардлагатай файлыг нэмэлтээр ААН-с авч, бүртгэлийн мэдээллийг буцаах шаардлагагүйгээр шууд хавсаргах боломжийг бүрдүүлэх;<br>- ЭУХ-ээс өгсөн дотоод зурвасын дагуу тус програмд нэмэлт сайжруулалт; | | |
| 8 | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Эхний хагас жилд: Нэгжийн эрсдэлийг таньж тогтоож сан үүсгэнэ.<br>Сүүлийн хагас жилд:<br>1.Нэгжийн эрсдэлийг таньж тогтоож сан | Мэдээллийн технологийн (МТ) салбарт эрсдэлийг удирдах нь байгууллагын үйл ажиллагааны найдвартай байдал, өрсөлдөх чадварыг хадгалахад чухал үүрэгтэй. Гаалийн байгууллагын Мэдээллийн технологийн газрын эрсдэлийг тодорхойлох нь байгууллагын мэдээллийн системийн найдвартай байдал, аюулгүй ажиллагаа, үр ашигтай байдлыг хангах чухал үндэс суурь юм. Мэдээллийн технологийн эрсдэлд хамаарах хүчин зүйлс нь | 01.01-11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | үүсгэн, түүнд дүн шинжилгээ хийж бууруулах арга хэмжээг авч ажиллана.<br>2.Бууруулсан эрсдэлийг санд бүртгэсэн талаар болон нэгжийн үйл ажиллагаанд учирсан ач холбогдол, үр дүнгийн талаар оновчтой тайлагнасан байна | байгууллагын мэдээллийн систем, өгөгдөл, тоног төхөөрөмж, ажилтнууд болон гадаад орчны олон талт нөлөөнөөс шалтгаалж үүсэж боломжтой.<br>МТГ-с үйл ажиллагаа, чиг үүргийг нарийвчлан судалж, байгууллагын мэдээллийн технологийн чиглэлд гарч болзошгүй дараах эрдслийн хүчин зүйлсийг тодорхойлсон.<br>• Тоног төхөөрөмжийн эвдрэл<br>• Сүлжээ, системийн тасалдал<br>• Програм хангамжийн алд аа<br>• Кибер халдлага<br>• Мэдээллийн алдагдал<br>• Мэргэшсэн ажилтны дутагдал<br>• Сургалт, хөгжлийн дутагдал<br>• Хүний нөөцийн тогтворгүй байдал<br>• Байгалийн гамшиг<br>• Төсвийн дутагдал<br>Үнэлгээний аргачлал нь эрсдэл бүрийг магадлал (тохиолдох боломж) болон нөлөөллийн (тохиолдсон тохиолдолд үзүүлэх нөлөө) түвшинг тодорхойлж, эрсдэлийн матрицад байршуулсан. Эрсдэлийн матрицад байршуулсанаас харахад өндөр, дунд, бага эрсдэлд дараах хүчин зүйлс орсон бөгөөд эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө гаргасан.<br>Тоног төхөөрөмжийн эвдрэл, сүлжээ тасалдал, төсвийн дутагдал зэрэг эрсдэлүүд байгууллагын үйл ажиллагаанд ноцтой нөлөө үзүүлэх тул яаралтай хяналт, шийдэл шаардлагатай. Технологийн шинэчлэл, мэргэшсэн ажилтны дутагдал зэрэг асуудлууд нь үйл ажиллагаанд зарим саад учруулж болох ч урт хугацаанд илүү том асуудал болж хувирах магадлалтай. Байгалийн гамшиг нь ховор тохиолддог ч тохиолдсон үед их хэмжээний нөлөө үзүүлдэг тул нөөц төлөвлөгөө шаардлагатай. | | |
| 9 | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Захиргааны зөвлөлийн хуралдаан, Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан, Онлайн, Шуурхайгаас болон бусад хэлбэрээр удирдлагаас өгөгдсөн нийт үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн | Захиргааны зөвлөлийн хуралдаан, Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан, Онлайн, Шуурхайгаас болон бусад хэлбэрээр удирдлагаас өгөгдсөн 16 үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлж, тухай бүр ЗДАС-ийн Үүрэг даалгаврын програмд оруулсан. Үүрэг даалгаврын төрлөөр нь ангилвал:<br>- Үүрэг даалгавар 11<br>- Зөвлөмж 2<br>- Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан 1<br>- Онлайн хурлын даалгавар 1<br>- Ёс зүйн дэд хорооны хуралдаан 1 | 01.01-11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | биелүүлж, тухай бүр тайлагнасан байна. | | | |
| 10 | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулж, цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид тогтмол бүртгүүлж, гадуур ажилласан, өвчтэй, чөлөөтэй тохиолдол бүрт СЕРП программаар тухай бүр илгээж ажиллсан байна. | Тайлант хугацаанд ажлын өдрийн өглөө, орой бүр цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид цагаа бүртгүүлж, нийт 23 хүсэлтийг тус тус Захиргаа дотоод ажлын системд тухай бүрт илгээж, хянуулсан.<br>• Томилолтоор ажиллах 1;<br>• Хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох 18;<br>• Ээлжийн амралтын 1;<br>• ЗББНДБ чөлөө 2;<br>• Бусад 1; | 01.01-11.30 | 100 |
| 11 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /Стратеги 1.4.35.Автозамын хилийн боомтуудын хилээр нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, дэд бүтцийг өргөтгөн шинэчлэх/ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1.Алтанбулаг боомтын бүтээн байгуулалтын барилгын ажил 100%-д хүрч дууслаа. Боомтын барилгын дотоод тохижилт, хаягжилт, тэмдэг, тэмдэглэгээ, тоноглол, гаалийн хяналт шалгалтын зарим тоног төхөөрөмжийг суурилуулж ашиглалтад хүлээж авах ажлыг зохион байгуулсан байна.<br>2.Бичигт боомтын бүтээн байгуулалтын барилгын ажил 50%-д хүрсэн байна.<br>3.Шивээхүрэн боомтын бүтээн байгуулалтын барилгын ажлыг эхлүүлсэн байна. | Алтанбулаг боомт, Бичиг боомт, Шивээхүрэн боомтын бүтээн байгуулалтын ажил дуусаагүй учир тоног төхөөрөмжийг суурилуулах ажил хийгдээгүй хүлээгдэж байна. | 01.01-11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /1.4.24 Гаалийн хяналт бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд "Бараа бүртгэлийн нэгдсэн систем"-ийг ашиглах/ | Үйл ажиллагаа | | Сүүлийн хагас жилд:<br>1."Бараа бүртгэлийн нэгдсэн систем" бүрэн ашиглалтад орсны дараа гаалийн мэдүүлэг тус бүрээр барааны борлуулалтын мэдээг авч, гаалийн хяналт шалгалт болон бүрдүүлэлтийн дараах шалгалтад ашиглаж, илрүүлсэн зөрчлийн тоо өмнөх оны мөн үеэс 5 хувиар өссөн байна.<br>2. Экспорт, импортын бүх барааг гаалийн бүрдүүлэлтийн систем эсхүл "Бараа бүртгэлийн нэгдсэн систем" -ээс баркоджуулан эцсийн хэрэглэгч хүртэл бүртгэл хөтөлж, "Бараа бүртгэлийн нэгдсэн систем" бүрэн ашиглалтад орсны дараа бүх аж ахуйн нэгж, иргэд бүрэн ашиглах боломжийг бүрдүүлсэн байна. | Бараа бүртгэлийн нэгдсэн систем нь хилээр орж, гарч буй бараанд баркодоор хяналт хийх зориулалттай систем бөгөөд гаалийн мэдүүлэг нөхөн бичих үед баркодыг оруулах, баркодыг оруулаагүй гаалийн мэдүүлгийг "Бараа бүртгэлийн нэгдсэн систем"-с баркодыг нөхөж оруулах боломжтой.<br>Гаалийн мэдүүлэгт нөхөн бичихэд барааны баркодыг дараах байдлаар оруулах боломжтой хөгжүүлэлт хийж, ББНС-рүү мэдээллийг цахимаар илгээж байна.<br>• ББНС-н баркодын сангаас татах<br>• Лабораторын дүгнэлтээс татах<br>• Эм, эмнэлгийн хэрэгслийн импортын лицензээс татах<br>• ОАТ архи, согтууруулах ундааны акц, лицензээс татах<br>• Автомашин, уул уурхайн бүтээгдэхүүн зэрэг баркодгүй задгай бараанд гаалийн системээс автомат баркод үүсгэх<br><br>2024.01.01 – 2024.11.30ны байдлаар импортын мэдүүлгийн 276,592, экспортын мэдүүлгийн 676,775 бараа баркодтой бүрдүүлэлт хийж ББНС-рүү илгээсэн байна.<br><br>Нэмэлтээр Лабораторийн дээжинд харгалзах үр дүнг нөхөн бичих явцад онцгой албан татвар бүхий бараануудын БАРКОД-ыг Бараа Бүртгэлийн Нэгдсэн Системээс татан авч шалган харгалзах БТКУС код байхгүй үед тухайн баркодонд харгалзах БТКУС кодыг ББНС-н баркодын сан руу илгээх хөгжүүлэлт хийсэн.<br><br>Мөн ОАТ-тай архи, согтууруулах ундааны гаалийн бүрдүүлэлтэд баркодод үндэслэн ХХААХҮЯамнаас олгодог импортын лицензийг цахимаар татах, ТЕГ-н цахим системд ОАТ-н акцыг захиалахад мэдүүлгийн баркодод үндэслэн захиалах хөгжүүлэлт хийж, нэвтрүүлсэн.<br><br>Худалдааг хөнгөвчлөх, хил дээр урсгалд ачаалал өгөхгүйн тулд Гаалийн мэдүүлэгт баркод нөхөн бичээгүй тохиолдолд татвар төлөгч ББНС-г ашиглан гаалийн мэдүүлэгт баркод нөхөн оруулах, хэрэглээг ТЕГ-с жигдрүүлэх шаардлагатай. | 01.01-11.30 | 100 |
| 13 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | Хэрэгжилт,гүйцэтгэлээр | - | 1. ОУАТХ-ны програм хангамжийн багтай цахимаар холбогдож ажиллана. | 1. ОУАТХ-ны програм хангамжийн багтай цахимаар холбогдож ажилласан.<br>2. IRU олон улсын байгууллага болон Монголын авто тээвэрчдийн нэгдсэн холбоо (НАРТАМ) -тай хамтран TIREPD, e-TIR системүүдтэй мэдээллийг цахимаар солилцох, КАИС програмын тээврийн бүртгэл, манифестийн програмтай | 01.01-11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | /1.4.29. IRU олон улсын байгууллага болон Монголын авто тээвэрчдын нэгдсэн холбоо (НАРТАМ) -той хамтран TIR-EPD, e-TIR системүүдтэй мэдээллийг цахимаар солилцох/ | | | 2. IRU олон улсын байгууллага болон Монголын авто тээвэрчдийн нэгдсэн холбоо (НАРТАМ) -тай хамтран 2.TIR-EPD, e-TIR системүүдтэй мэдээллийг цахимаар солилцох программыг туршиж, нэвтрүүлнэ. | холбох хөгжүүлэлт хийн, туршиж, 2024.11.08-ны өдрөөс амжилттай нэвтрүүлсэн. | | |
| 14 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /1.4.27 Цахим гарын үсгийг гаалийн байгууллагын хэмжээнд нэвтрүүлэх/ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1.Системийн хэмжээнд удирдлагууд, хяналт, шалгалт хийж буй гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч нарыг тоон гарын үсэгтэй болгож тоон гарын үсгийг гаалийн мэдээллийн систем рүү нэвтрэх, бичиг баримтыг үнэлэх, хяналт, шалгалт хийх, зөвшөөрөл өгөх үйлдлүүд болон гаалийн байгууллагын дотоод үйл ажиллагаанд тоон гарын үсгийг ашигладаг болсон байна.<br>2.Төрийн болон төрийн бус | 1. Системийн хэмжээнд удирдлагууд, хяналт, шалгалт хийж буй гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч нарыг тоон гарын үсэгтэй болгож тоон гарын үсгийг гаалийн мэдээллийн систем рүү нэвтрэх, бичиг баримтыг үнэлэх, хяналт, шалгалт хийх, зөвшөөрөл өгөх үйлдлүүд болон гаалийн байгууллагын дотоод үйл ажиллагаанд тоон гарын үсгийг ашиглах боломжийг бүрдүүлсэн.<br>2. Төрийн болон төрийн бус хувийн 4000 гаруй байгууллагуудтай тоон гарын үсэг ашиглан тоон гарын үсгээрээ баталгаажуулалт хийж цахимаар албан бичиг солилцохыг бүрэн нэвтрүүлсэн. | 01.01-11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байгууллагатай харилцахдаа тоон гарын үсгийг ашиглаж эхэлсэн байна | | | |
| 15 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /Архивын төлөвлөгөө- Байгууллагын архив, бичиг хэргийг цахимжуулах/ | Үйл ажиллагаа | - | Сүүлийн хагас жилд:<br>1.Архивын лавлагааг /Гаалийн мэдүүлгээс бусад/ 100 хувь цахимжуулсан байна.<br>2.Гаалийн ерөнхий газар болон харьяа гаалийн газар, хороод хоорондын албан бичиг хүлээн авах, хүргүүлэх ажил бүрэн хийгдсэн, 100 хувь цахимжсан байна. | 1. Архивын лавлагааг цахимжуулах ажлын хүрээнд 19 гаалийн газар хороо болон гаалийн ерөнхий газарт ирсэн, явсан албан бичиг нь цахим бичиг хэрэг хөтлөлтийн иДок системээр дамжиж байгаа тул бүрэн цахим архивд орсон. Мөн 2004-2018 оны гаалийн ерөнхий газрын А,Б тушаалын баримтуудыг Идок, архивын систем дээр цахимжуулах ажил 90%-тай хийгдсэн. Иймд дээрхи баримтуудын архивын лавлагааг тоон гарын үсгээр баталгаажуулан Идок системээр олгох боломжтой.<br>2. Цахим бичиг хэрэг хөтлөлтийн Идок системээр албан бичгийг 100% цахимаар илгээх, хүлээн авах програмын даалгаврыг гүйцэтгэгч компанид захиалга өгсөн. Програмын хөгжүүлэлт дууссаны дараа 2024.05.06, 2024.07.29 -ны өдөр туршилт хийж, програмын түвшинд гарсан алдааг Нью соник ХХК-д хандан засуулсан. Сүүлийн туршилтыг 2024.12.03-ны өдөр хийхэд алдаа гараагүй, Б.Ганзориг даргын гарын үсгээр 3 албан бичгийг тоон гарын үсгээр баталгаажуулан, цахимаар явуулсан.<br><br>Цахим бичиг хэрэг хөтлөлтийн Идок системээр тоон гарын үсгээр баталгаажуулсан албан бичиг цахимаар явуулах бүрэн боломжтой болсон.<br><br>Ерөнхий газрын дарга нар тоон гарын үсгийн төхөөрмжийг авсан, харья газар хороодын дарга нарт тоон гарын үсгийн төхөөрөмж бэлэн болсон тарааж өгөх ажил хүлээгдэж байгаа. | 01.01-11.30 | 100 |
| 16 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /1.4.35.Автозамын хилийн боомтод суурилуулсан ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг ашиглан хил | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1.Хил хамгаалах ерөнхий газартай хамтарсан ажлын хэсэг байгуулж, солилцох мэдээллийг тохирсон байна. | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Хилийн удирдлагын нэгдсэн систем ХУН” төслийн хүрээнд ХХЕГ, ГЕГ-н мэдээллийн нэгтгэх ажил хийгдэж байна. Уг ажлын хүрээнд:<br>• Хилээр орох чиглэл эхлэж ХХЕГ-т тээврийн хэрэгслийн орох бүртгэлийн бүртгэж, цахимаар гаалийн байгууллагад илгээнэ.<br>• Хилээр гарах чиглэлд эхлэж Гаалийн байгууллага тээврийн гарах бүртгэлийг КАИС системд бүртгэж, ХХЕГ-руу цахимаар илгээнэ. Үүний дараа ХХЕГ-с тухайн тээврийн хэрэгслийн жолооч, зорчигчийн мэдээллийг бүртгэж, гаалийн байгууллагад илгээнэ.<br>• “ХУН” системийн холболтын модуль ашиглан чөлөөт бүсийн дэлгүүр, үйлдвэрийн газар нэг талаас нөгөө талаас Хил | 01.01-11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамгаалах байгууллагатай хамтран ажиллаж, хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг нэгтгэнэ./ | | | | хамгаалах ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Замын-Үүд Чөлөөт бүсийн захирагчийн алба нэг цогц болж үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх зорилгоор Гаалийн автоматжуулсан мэдээллийн системд (КАИС) нэмэлт өөрчлөлт оруулах, Хилийн удирдлагын нэгдсэн тогтолцоонд холбох програмын хөгжүүлэлтийг гүйцэтгэж, туршилтаар нэвтрүүлэхээр 2024.11.11-2024.11.14-ны хооронд Замын-Үүд дэх Чөлөөт бүсэд ГЕГ, ХХЕГ, Гэрэгэ системс ХХК, Аствишн ХХК гэсэн 4 байгууллагын ажлын хэсэг томилогдон ажилласан. | | |
| 17 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /1.4.35. Тээврийн хэрэгсэл эзэмшигч нар хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг гар утаснаасаа гаалийн байгууллагын CAIS системд илгээх, мобайл аппликейшн шинээр хийлгэх/ | Үйл ажиллагаа | - | Сүүлийн хагас жилд:<br>1.Тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг гар утаснаасаа гаалийн байгууллагын CAIS системд илгээх, мобайл аппликейшн шинээр хийлгэх бодлогын даалгавар боловсруулж, Мэдээллийн технологийн төвд хүргүүлнэ.<br>2.Мобайл аппликейшн туршилтаар ашигласан байна. | • Тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг гар утаснаасаа гаалийн байгууллагын CAIS системд илгээх, мобайл аппликейшний хөгжүүлэлтийг И-Монгол академи УТҮГ-аар хийлгэхээр болсон. Тус асуудлаар 2 удаагийн уулзалтыг зохион байгуулж ажилласан.<br>• Хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийг иргэд, ААН-үүд гааль.мн системд 72 цагийн өмнө бүртгүүлэн, КАИС системд илгээснээр уг тээврийн хэрэгсэл хил дээр ирэхэд байцаагч баталгаажуулалт өгөх хилээр нэвтрэх боломжтой болгон системийн хөгжүүлэлт хийж нэвтрүүлсэн. Гааль.мн -ы тээврийн хэрэгслийн бүртгэлийг ашиглан нийт 1,005,224 тээврийн хэрэгсэл бүртгүүлсэн байна. | 01.01-11.30 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, сургалтын тоогоор | - | Хууль эрх зүйн мэдлэг, мэдээллээ бататгаж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | 1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай А3 сургалтад хамрагдаж сертификат авсан.<br>2. Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яамнаас зохион байгуулсан "Монгол Улсын Үндэсний өгөгдлийн засаглалын тогтолцоо болон дижитал засаглал" сэдэвт семинарт 2024 оны 12 дугаар сарын 3, 4-ний өдрүүдэд оролцсон. | 05.14-05.16 | 100 |
| 2 | IELTS Англи хэлний сургалтад суух | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Англи хэлний мэдлэгээ дээшлүүлж IELTS оноо авах. | "Speak AI", NeoLingo зэрэг Англи хэл сурах апп-г ашиглан Англи хэлний чадвараа сайжруулсан. | 01.01-06.05 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН
ГАЗРЫН ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ ........................ /Н.МӨНХЗУЛ/ 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

1241

# ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Н.МӨНХЗУЛЫН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Мэдээллийн технологийн газар

## 1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| Зорилт 4.“Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”зорилтыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт | | | | | |
| 1. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /1.1.26.Гадаад худалдааны цахим нэг цонхны системийг бий болгох/ | 60 | 8 | 68 | |
| 2. | Мэдээллийн нэгдсэн санд дүн шинжилгээ хийж, өгөгдлийг боловсруулсан байдал | 58 | 8 | 66 | |
| 3. | Мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгох, аюулгүй байдлыг хангах, тоног төхөөржмийн судалгаа хийсэн байдал. | 60 | 10 | 70 | |
| 4. | Программ хангамжуудыг шинээр боловсруулах, хөгжүүлсэн байдал | 55 | 8 | 63 | |
| 5. | Албан хаагчдын чадавхыг бэхжүүлсэн байдал | 60 | 10 | 70 | |
| 6. | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | 60 | 10 | 70 | |
| 7. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | 58 | 9 | 67 | |
| 8. | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | 56 | 8 | 64 | |
| 9. | Үүрэг даалгаврын биелэлт | 60 | 9 | 69 | |
| 10. | Ажлын цаг ашиглалт | 55 | 8 | 63 | |
| 11. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг | 55 | 8 | 63 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | үүргийн хэрэгжилт /Стратеги 1.4.35.Автозамын хилийн боомтуудын хилээр нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, дэд бүтцийг өргөтгөн шинэчлэх/ | | | | |
| 12. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /1.4.24 Гаалийн хяналт бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд "Бараа бүртгэлийн нэгдсэн систем"-ийг ашиглах/ | 58 | 8 | 66 | |
| 13. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /1.4.29. IRU олон улсын байгууллага болон Монголын авто тээвэрчдын нэгдсэн холбоо (НАРТАМ) -той хамтран TIR-EPD, e-TIR системүүдтэй мэдээллийг цахимаар солилцох/ | 55 | 8 | 63 | |
| 14. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /1.4.27 Цахим гарын үсгийг гаалийн байгууллагын хэмжээнд нэвтрүүлэх/ | 55 | 8 | 63 | |
| 15. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /Архивын төлөвлөгөө- Байгууллагын архив, бичиг хэргийг цахимжуулах/ | 59 | 9 | 68 | |
| 16. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /1.4.35.Автозамын хилийн боомтод суурилуулсан ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг ашиглан хил хамгаалах байгууллагатай хамтран ажиллаж, хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг нэгтгэнэ./ | 58 | 8 | 66 | |
| 17. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /1.4.35. Тээврийн хэрэгсэл эзэмшигч нар хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг гар утаснаасаа гаалийн байгууллагын CAIS системд илгээх, мобайл аппликейшн | 58 | 8 | 66 | |

| | шинээр хийлгэх/ | | | |
|---|---|---|---|---|

## 2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах | 100 | 15 | |
| 2. | IELTS Англи хэлний сургалтад суух | 100 | 15 | |
| | **Дундаж оноо:** | | 15 | |

## 3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2. | Асуудал шийдвэрлэх | 7 | |
| 3. | Хариуцлагатай байдал | 7 | |
| 4. | Дүн шинжилгээ хийх | 7 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| | **Дундаж оноо:** | **7** | |

## 4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

| Д/д | Хандлага, ёс зүй, ур чадвар | Хамт олны үнэлгээ (0-8) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 8 |
| 2. | Багаар ажиллах | 8 |
| 3. | Харилцаа | 7 |
| | **Дундаж оноо: 7.6** | |

## 5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)* | *66.7* |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | *15* |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | *7* |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | *7.6* |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо =** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* )- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | **96.3** |

***Үнэлгээ өгсөн:***

***Нэгжийн дарга***
Мэдээллийн технологийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ................................ (Б.Ганзориг)

2024-12-10 (огноо)

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

***Төрийн жинхэнэ албан хаагч: зөвшөөрсөн:***
Гаалийн улсын ахлах байцаагч ................................ (Н.Мөнхзул)

2024-12-10 (огноо)

***Үнэлгээг хянасан:***

***Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:***
Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ................................ (Г.Энхтайван)

XII/20, 2024 (огноо)

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***
Хүний нөөцийн хэлтсийн Гаалийн улсын ахлах байцаагч

.............................. (Ө.Тэгшээ)

2024.12.20 ..............................*(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:***

***Төсвийн шууд захирагч***
Гаалийн ерөнхий газрын дарга .............................. (Р.Отгонжаргал)

..............................*(огноо)*